

УЛААНБААТАР ХОТ  
2020 он



**“Эрдэнэс-Тавантолгой” ХК**

Огноо: .....

**“HYUNDAI STAREX H1” МАРКЫН АВТО МАШИНЫ СЭЛБЭГ  
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:	<b>“HYUNDAI STAREX H1” маркын авто машины сэлбэг нийлүүлэх сонгох</b>
Харьцуулалт/ гэрээний дугаар:	<b>ЭТТ/202001110</b>

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**“Эрдэнэс-Тавантолгой” ХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“HYUNDAI STAREX H1”** маркын авто машины сэлбэг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын цахим систем болох [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 10 цаг 40 минутад “Эрдэнэс Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 1 давхрын хурлын өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,  
Финанс төв 5 давхар, 503 тоот, Улаанбаатар-15160  
Утас: 75055555-504, Факс: 70118464,**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендер оролцогч ба эрх бүхий бараа</b>  | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |

- |  |   |
|--|---|
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>      | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.  |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>       | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| <b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b> | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.   |
-

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ- НЫ холбогд ох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>➤ Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>➤ Үнийн санал /нэр төрөл болон бүлэг тус бүрээр үнийн саналыг дэлгэрэнгүй ирүүлэх/</li> <li>➤ Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших байдлаар/</li> <li>➤ Тендер нээх өдрөөр татварын өр буюу дутуу үлдэгдэлгүй байх</li> <li>➤ Тухайн чиглэлээр ажил, үйлчилгээ явуулж байсан талаархи компанийн танилцуулга</li> <li>➤ 2018, 2019 онд ижил төстэй бараа нийлүүлсэн 2-оос доошгүй гэрээний хуулбар гэрээ дүгнэсэн акт эсхүл тухайн газрын тодорхойлолт ирүүлэх.</li> <li>➤ Заасан маркийн автомашины сэлбэг, эд ангийг нийлүүлэх зөвшөөрөлтэй буюу үйлдвэрлэгч, дистрибьютер, албан ёсны гэрээт борлуулагчийн аль нэгээр ажилладаг болохыг нотлох баримт бичиг, гэрчилгээ, гэрээний хуулбар зэргийг баталгаат орчуулгаар орчуулга хийлгэж ирүүлэх;</li> <li>➤ Нийлүүлэхээр санал болгож буй барааны үйлдвэрийн баталгаа бүхий шинэ сэлбэг, хэрэгслийн нэр загвар, техникийн тодорхойлолт ирүүлэх,</li> <li>➤ Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтсан техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасан бараа бүтээгдэхүүн нийлүүлэх түүнтэй холбоотой аливаа эрсдлийг бүрэн хариуцхийг баталсан албан бичиг ирүүлнэ.</li> </ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендерийг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын цахим системд ирүүлэх</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 10 цаг 40 минутад “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхрын хурлын өрөөнд нээнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>багцгүй</i></p>

## 1. Барааны тодорхойлолт:

- ✓ Захиалагчид нийлүүлэх сэлбэг хэрэгслэл нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй байна.
- ✓ Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь захиалагчын гаргасан захиалгийн, тоо ширхэгт үндэслэн гүйцэтгэлээр нийлүүлэгдэнэ.
- ✓ Нийлүүлэгч нь сэлбэг эд ангийг хүснэгт 1-т заагдсан HYUNDAI STAREX H1 маркийн автомашины арлын дугаар, үндсэн үзүүлэлтүүдээр, хавсралт 1-т заагдсан сэлбэгийн дугаараар шалгаж таарах сэлбэгийн баталгаа ирүүлнэ.
- ✓ Хавсралт 1-т заагдсан сэлбэгийн жагсаалтаас гадна тус автомашины бүх төрлийн сэлбэг, эд ангийг нийлүүлэх чадамжтай байна.
- ✓ Хавсралт 1-т тусгагдаагүй сэлбэг, эд анги худалдан авах шаардлага үүссэн тохиолдолд захиалагчийн хүсэлтээр шаардлагатай сэлбэгийн жагсаалтыг гарган гэрээнд (хавсралт 2,3 г.м) нэмэлт өөрчлөлт оруулах ба нийлүүлэгч компани тухайн сэлбэгийг зах зээлийн дундаж ханшаар нийлүүлнэ.
- ✓ Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь техникт таарахгүй (Сэлбэгийн дугаар зөрсөн) тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж таарах сэлбэг, эд ангиар сольж өгөх үүрэг хүлээнэ.

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

HYUNDAI COUNTY маркийн автобусны сэлбэг, эд анги доорх (хүснэгт-1)-т заагдсан үндсэн үзүүлэлт, хөдөлгүүрийн загвар, сериалын дагуу шалгаж баталгаажуулсан, тухайн үйлдвэрлэгчийн албан ёсны борлуулагч байх шаардлагатай.

### HYUNDAI STAREX H1 маркийн автомашины үзүүлэлт

Хүснэгт 1

№	Модель	Үйлдвэрлэсэн он	Улсын дугаар	Хөдөлгүүрийн дугаар	Арлын дугаар
1	HYUNDAI STAREX H1	2013	64-89УНБ	G4KGDА337398	KMJWA37RADU583956
2	HYUNDAI STAREX H1	2016	21-89УНБ		KMJWA37RAGU857434

№	Ангилал	Сэлбэгийн нэр	Хэмжих нэгж	Тоо,ш
1	Техник үйлчилгээ	Бензин шүүр	ш	6
2	Техник үйлчилгээ	Тосны шүүр	ш	22
3	Техник үйлчилгээ	Агаар шүүгч	ш	22
4	Техник үйлчилгээ	Салоны агаар шүүгч	ш	22
5	Хөдөлгүүр	Стартер	ш	2
6	Хөдөлгүүр	Жанам	ш	2
7	Хөдөлгүүр	Жанамны ремин	ш	4
8	Хөдөлгүүр	A/C ремин	ш	4
11	Явах эд анги	Урд босоо тэнцүүлэгч (R,L-тал)	Ком	2
12	Явах эд анги	Хойд босоо тэнцүүлэгч (L,R-тал)	Ком	2
13	Явах эд анги	Урд наклад	ком	2
14	Явах эд анги	Хойд наклад	ком	2
15	Явах эд анги	Зогсоолын тормозны наклад	ком	2
16	Явах эд анги	Зогсоолын тормозны тросс	ш	2
17	Явах эд анги	Урд амартизатор	ш	8
18	Явах эд анги	Хойд амартизатор (Втулка хамт)	ш	8
19	Явах эд анги	Урд амартизаторын пүрш	ш	8
20	Явах эд анги	Хойд пүрш	ш	8
21	Явах эд анги	Урд амартизаторын дээд таваг	Ком	4
22	Явах эд анги	Урд хэвтээ тэнцүүлэгчийн дэр резин	Ком	4
23	Явах эд анги	Хойд хэвтээ тэнцүүлэгчийн дэр резин	Ком	4
24	Явах эд анги	Урд хэвтээ тэнцүүлэгчийн дамар резин	Ком	4
25	Явах эд анги	Хойд хэвтээ тэнцүүлэгчийн дамар резин	Ком	4
26	Явах эд анги	Дээд гар	Ком	2
27	Явах эд анги	Доод гар	Ком	2
28	Явах эд анги	Доод гарны өндөгөн тулгуур	Ком	4
29	Явах эд анги	Дээд гарны өндөгөн тулгуур	Ком	4
30	Явах эд анги	Заалны гүйдэг хаалганы цоож L тал	ш	4
31	Явах эд анги	Заалны гүйдэг хаалганы цоож R тал	ш	4
32	Явах эд анги	Заалны хаалганы гадна бариул L тал	ш	4
33	Явах эд анги	Заалны хаалганы гадна бариул R тал	ш	4
34	Явах эд анги	Заалны хаалганы дотор бариул L тал	ш	4
35	Явах эд анги	Заалны хаалганы дотор бариул R тал	ш	4
36	Явах эд анги	Заалны хаалганы ролик L,R	ком	2
37	Явах эд анги	Урд хаалганы цоож L /тросстой/	ш	2
38	Явах эд анги	Урд хаалганы цоож R /тросстой/	ш	2
39	Явах эд анги	Урд хаалганы гадна бариул R тал	ш	2
40	Явах эд анги	Урд хаалганы гадна бариул L тал	ш	2
41	Явах эд анги	Урд хаалганы дотор бариул R тал	ш	2
42	Явах эд анги	Урд хаалганы дотор бариул L тал	ш	2
43	Явах эд анги	Урд цафпны үзүүрийн шарик	ш	4
44	Явах эд анги	Урд цафпны угийн шарик	ш	4
45	Явах эд анги	Хойд цафпны үзүүрийн шарик	ш	4
46	Явах эд анги	Хойд цафпны угийн шарик	ш	4
47	Явах эд анги	Дунд гук кардан голын хамт	Ком	1
48	Жолоодлогын механизм	Рулийн аппаратны хөндлөн тяга	Ком	2
49	Жолоодлогын механизм	Рулийн шарнер	Ком	2
50	Жолоодлогын механизм	Рулийн доод аппарат	Ком	2
51	Жолоодлогын механизм	Жолоодлогын гидрийн насос	Ком	2

52	Цахилгаан	Их гэрлийн ламп	ш	12
53	Цахилгаан	Ойрын гэрлийн ламп	ш	12
54	Цахилгаан	Кабины гэрлийн ламп	ш	12
55	Хүч дамжуулах анги	Муфьт шарик	ш	2
56	Хүч дамжуулах анги	Чагтан гол	ш	2
57	Хүч дамжуулах анги	Флянц	ш	2
58	Хүч дамжуулах анги	Ган диск	ш	2
59	Хүч дамжуулах анги	Пирда диск	ш	2
60	Хүч дамжуулах анги	Дээд консны аппарат	ш	1
61	Хүч дамжуулах анги	Доод консны аппарат	ш	1
62	Бусад	Салхины шил	ш	1
63	Бусад	Шил арчигчийн щётка	Ком	8
64	Хөдөлгүүр	Эйр кондишны компрессор	Ком	1
65	Бусад	Их гэрэл	Ком	2
66	Бусад	Хойд гэрэл	Ком	2
67	Хөдөлгүүр	Хөргөлтийн радиатор	Ком	1
68	Бусад	Рулийн уян	Ком	1
69	Бусад	Хос тросс	Ком	1
70	Хөдөлгүүр	Усны насос	Ком	1
71	Бусад	толь	Ком	1
72	Бусад	Обуд	ш	4
73	Бусад	Бензин насос	ш	1
74	Хөдөлгүүр	Свеча (очлуур)	ш	4
75	Хөдөлгүүр	Катушка	ш	4
76	Хөдөлгүүр	Духны сальник	ш	1
77	Хөдөлгүүр	Крышканы жийрэг	Ком	1
78	Хөдөлгүүр	Хөдөлгүүрийн жийрэг	Ком	1

2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
3. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
4. **Бараа хүргэх газар:** [Эрдэнэс Тавантолгой ХК-ын Улаанбаатар хотын агуулах]



5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тооширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-Д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
“HYUNDAI STAREX H1” маркын автомашины сэлбэг	<i>Техникийн тодорхойлолтын дагуу</i>	4	<i>бүлэг</i>	<i>ЭТТ компаний Улаанбаатар хот дахь агуулахад</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш 7 хоног</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш 1 жил, Захиалагчийн гаргасан захиалгын дагуу гүйцэтгэлээр</i>	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

**Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |

- 10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасны дагуу барааг хүлээн авах үед Захиалагч талыг төлөөлж захиалагчийн сонгосон эрх бүхий этгээд барааг шалгаж хүлээн авна. Барааг шалгахтай холбоотой бүхий л зардлыг Гүйцэтгэгч тал хариуцна
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;
  - 2) Бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгэ, бусад шаардлагатай бичиг баримт
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)** 7.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:  
*Захиалагчийн гаргасан захиалгын дагуу гүйцэтгэлээр төлбөр төлнө.*
- Урьдчилгаа төлбөр олгохгүй бараа нийлүүлсний дараа олгоно.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>** 9.1. Алданги оногдуулах хувь: **[өдөрт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1%]**
- Алдангийн нийт дүн: **[Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50%- с хэтрэхгүй]**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

БАТЛАВ.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.



5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.